

ДУНДАД ЗУУНЫ
ТҮҮХЭЭР ХАМТДАА
АЯЛЦГААЯ!



ЧИНГИСИЙН
ЭРИЙН ҮЕИЙН
ДЭЛХИЙ ДАХИН
(XII-XV) ЗУУН


ГАРАА

I.ӨРТӨӨ



ДУНДАД
ЗУУНЫ
ТҮҮХИЙГ
ХЭРХЭН
СУДЛАХ
ВЭ?

II.ӨРТӨӨ




ЧИНГИСИЙН
ЭРИН ҮЕИЙН
ӨМНӨХ
МОНГОЛ
(VI-XII зуун)

III.ӨРТӨӨ



ЧИНГИСИЙН
ЭРИН ҮЕИЙН
ӨМНӨХ ӨРНӨ
ДАХИН




VII.ӨРТӨӨ

МОНГОЛЫН
ЭЗЭНТ
ГҮРЭН




VI.ӨРТӨӨ



ИХ
МОНГОЛ
УЛС

V.ӨРТӨӨ

ЧИНГИСИЙН
ЭРИН ҮЕИЙН
ӨМНӨХ ДОРНО
ДАХИН



IV.ӨРТӨӨ



БАРИА



БИД ДУНДАД
ЗУУНЫ МОНГОЛ БА
ДЭЛХИЙ ДАХИНЫ
ТҮҮХИЙГ МЭДЛЭЭ



v.ӨРТӨӨ

V. ИХ МОНГОЛ УЛС

Тэмүжин бага насандаа өнчирч үлдэн хатуу бэрхийг ханатал амссан ч алсын хараа, хэтийн зорилготой эр болон өсөж, дайн самууны хөлд нэрвэгдсэн тархай, бутархай олон монголчуудыг нэгтгэн их улсыг байгуулжээ. Түүний нэвтрүүлсэн цэрэг, улс төр, нийгмийн шинэчлэлүүд нь дундад үеийн түүхэнд монголчуудыг товойн гарч ирэх үндэс болсон юм. Их эзэн Чингис хааны үйл хэрэг Монголын төдийгүй дэлхийн түүхэнд дахин давтагдашгүй их өөрчлөлтүүдийг эхлүүлсэн бөгөөд энэ утгаараа дэлхийн II мянганы суут хүнээр нэрлэгджээ.

7.1a



Чингис хааны талаар бид юу мэдэх вэ?



Д1

Миний мэдэх Чингис хаан нь.....
..... байсан.

б) Дараах асуултад хариуулаарай найзуудаа!

Би хэн бэ?


Би бол Чингис хааны эцэг.

Би юу вэ?

Чингис хаан намайг бий болгож, нийгмийн харилцааг зохицуулсан.

Би хаана байна вэ?

Энэ л газар хожмын их хаан Тэмүжин мэндэлжээ.



Тусламж

- Сурах бичгийн 70-

73-р тал

-Теле хичээл:

“Чингис хааны

түүхээс”

[https://](https://econtent.edu.mn/telelesson/7/13/3012)

[econtent.edu.mn/](https://econtent.edu.mn/telelesson/7/13/3012)

[telelesson/7/13/3012](https://econtent.edu.mn/telelesson/7/13/3012)





Чингис хааны тухай илүү ихийг мэдэцгээе!



7.2a


Д2

Хүүхдүүдээ бид I бүлгийн хичээлээр билгийн жилийг аргын онд, аргын оныг билгийн жилд томъёо, хүснэгтийн тусламжтайгаар хэрхэн шилжүүлэх тухай үзсэн билээ. Энэ удаад аргын оныг билгийн жилд шилжүүлэх хялбар аргыг сурцгаая.

Заавар: Аргын оныг билгийн жилд шилжүүлэхдээ аргын оноос 3-ыг хасч, үлдэгдлийг нь 12 хуваана.

Жишээ нь: 1966 оныг билгийн жилд шилжүүлье. $1966 - 3 = 1963 / 12 = 163 (7)$ бүхэл ноогдвор бус үлдэгдэл 7 нь билгийн жилийн дугаарыг заана. Билгийн 12 жилийн 7 дахь жил нь морь жил болно.

а) Энэ аргаар Чингис хааны мэндэлсэн 1162 оныг билгийн жилд шилжүүлээрэй.



б) Эх сурвалжийг задлан шинжилцгээе!

“Чингис хааны язгуур. Дээр тэнгэрээс заяат төрсөн Бөртэ чоно ажгуу. Гэргий нь Хоо ажээ. Тэнгис гэтэлж ирэв. Онон мөрний тэргүүнээ Бурхан халдунаа нутаглаж Батцагаан хэмээх нэгэн хөвүүнийг төрүүлжээ.” (МНТ. УБ., 2011. §. 1)

1. Тэмүжиний дээд өвөг хэнээс эхэлж байна вэ?

.....

2. Энэ домгийн мэдээгээр Бөртэ Чоно хаана ирсэн бэ?

.....

в) Он тооллын шугам дахь мэдээллийг гүйцээгээрэй!



Яагаад Чингис хааныг дэлхийн II мянганы хүнээр тодруулсан гэж бодож байна хүүхдүүд ээ!



7.3a

Д3 Сурах бичгийн 70-73-р талыг уншин Монголын болон дэлхийн түүхэнд үлдээсэн Чингис хааны өвийн тухай ойлгож мэдсэнээ дараах түлхүүр үгсийг оролцуулан нэгтгэн дүгнээрэй.

- ◆ Өнчдийн авилга
- ◆ Их засаг
- ◆ Алтан аргамж
- ◆ Пакс Монголика
- ◆ II мянганы хүн

.....

.....

.....

.....

.....

.....



Тэмүжин хэрхэн Монгол улсын хаан болсон тухай илүү ихийг мэдэгцгээе!

7.16

Д4 Сурах бичгийн 74-р талыг уншин тулгуур ойлголтуудыг олж тохирох зайнд нөхөөрэй.

б	ө	н	х	б	л	р	ш	ц	и	с
д	а	л	а	н	б	а	л	ж	у	д
а	б	о	р	о	у	г	д	б	н	и
ж	б	ө	з	ё	ж	ц	ө	а	ю	э
ө	г	а	ү	э	м	э	р	г	и	д
ф	у	ж	р	ж	у	г	х	а	ө	м
с	а	о	х	э	р	э	й	д	ш	э
м	о	ө	н	о	д	ь	и	с	ё	ч
н	ү	о	и	т	н	у	б	ө	б	х
р	о	у	й	х	ө	х	н	у	у	р

- ⇒ Тэмүжин Мэраид-ийн довтолгоонд өртөж, эхнэрээ алджээ.
- ⇒ Тэмүжин эцгийн анд байсан улсын Тоорил хантай “Эцэг, хөвгүүний” харилцаа тогтоов.
- ⇒ гэдэг газар 28 настайдаа Монгол улсын хаанд өргөмжлөгджээ.
- ⇒ болсон тулаанд Чингис хаан ялагдав.



Чингис хаан нэгдсэн Монгол улсыг байгуулахын төлөөх үйл хэргүүдийг судалцгаая!

Д5

7.26

Сурах бичгийн 75-76-р талыг уншин дараах хүснэгтийг гүйцээгээрй.



Он цаг	Үйл явдал	Үр дүн
1189-1206	Тархай, бутархай Монголчуудаа нэгтгэж, нэгдсэн арми, хүчирхэг жанжидтай болов.
.....	Тэмүжин Улз голд зугатан ирсэн Татар аймгийг Тоорил хантай хамтран бут цохив.
1201	Монгол улс нэгэн зэрэг хоёр хаантай болов.
.....	Хүйтний тулаанд Чингис хаан ялав.
1202	Мэргид, Татар аймгуудыг эрхэндээ оруулжээ.
.....	Хэрэйд улс мөхөв.
1204
.....	Чингис хаан нэгдмэл Монгол улсаа байгуулжээ.

7.2в

Эх сурвалжийг задлан шинжлээрэй.

Д6

1. “Боорчу баруун гарын Алтай дэрлэхүүний түмнийг мэдтүгэй хэмээн зарлиг болов” (МНТ. УБ., 2011. §.205)
2. “Мухали гоо ван зүүн гарын Харагун жидүнийг (Хянганы нуруу) дэрлэхүүний түмэн мэдтүгэй хэмээн зарлиг болов” (МНТ. УБ., 2011. §. 206)
3. “Эдүгээ Наяа төвийн түмэн мэдтүгэй хэмээн зарлиг болов”. (МНТ. УБ., 2011. §. 220)
4. “Эртиш гудас ойн иргэнд хүртэл нутаг дархлан нутаглаж ойн иргэнийг даруулан Хорчи түмэн мэдтүгэй хэмээн зарлиг болов” (МНТ. УБ., 2011. §. 207)

а) Эх сурвалжийн тухай бид юу мэдэх вэ? Эх сурвалжийн ямар төрөлд хамаарах вэ?

.....

б) Эх сурвалжид юун тухай өгүүлж байна вэ?

.....


Их Монгол улс байгуулагдсаны ач холбогдлыг эрэмблэн тайлбарлацгаая найзуудаа!



7.36

Д7

а) Дараах өгөгдлүүдийн дугаарыг пирамид дотор ач холбогдлынх нь дарааллаар байрлуулна уу. (Доод хэсэгт суурь ач холбогдол хамгийн дээр түүнээс улбаалан бий болсон гэх мэт)



1. Аж ахуйн хөгжил түргэсэж, малын тоо толгой нэмэгдэв.
2. Хүн ам өссөн.
3. Монголчуудын амьжиргаа дээшилсэн.
4. Тусгаар байдлаа хамгаалах цэргийн хүчтэй болсон.
5. Дотоодын хямрал, дайн самуун зогссон.
6. Монголчуудын төр ёсны шинэ үе эхэлсэн.

б) Пирамидад Их Монгол улс байгуулагдсаны ач холбогдлыг хэрхэн эрэмблэн байрлуулсан шалтгаанаа тайлбарлаарай.

.....

.....


.....

Д7

а) Газарзүйн зурагт улсуудын байршлыг тэмдэглээрэй.



7.2г



- а) Их Монгол улс б) Тангуд улс в) Алтан улс г) Сүн улс
 д) Төвөд е) Хар Хятан улс ё) Солонгос

Д8

б) Эх сурвалжийг уншин Чингис хааны гадагш хийсэн аян дайны шалтгааныг тодруулаарай

7.2д

“Алтан ханы эсрэг дайлаар орохынхоо өмнө өөрийнхөө заншлаар овооны орой дээр ганцаар гарч бүсээ тайлж хүзүүндээ ороогоод дээлийнхээ товчийг тайлан өвдөг сөгдөж байж өгүүлрүүн Мөнх тэнгэр минь ээ, Алтан хаан самуун дэгдээх салхийг үүсгэж, хэрүүлийн эхийг тавьсныг та мэдэж захирч байгаа билээ. Татарууд баривчлан авч хүргүүлсэн гэм зэмгүй Охинбархаг, Амбагай хааныг минь хөнөөсөн билээ. Тэр бол миний аав, түүний өвөг дээдэс өвөг минь байсан болохоор цусан өшөөг тэднээс авах гэсэн байгаа билээ. Хэрэв чиний санаа шударга гэж болгоовол надад дээр тэнгэрээс хүч хайрла...Тэр мөргөлөө нэн их сүсэглэн үйлдэв” (Рашид-Ад-Дин. Судрын чуулган. УБ., 2002. II боть. II дэвтэр. III анги)

1. Чингис хаан Алтан улс руу довтлосон шалтгааныг тайлбарлана уу.

.....

.....

.....

2. Чингис хаан ямар шүтлэгтэй хүн байсан бэ?

.....

Д9

7.2e



Эх сурвалжийг уншин Чингис хааны гадагш хийсэн аян дайны шалтгааныг тодруулаарай.

“...Чингис хааны, сартаул иргэнд явуулсан Ухуна тэргүүтэн зуун элч алагдсанд, Чингис хаан өгүүлрүүн: “Алтан аргамжаа сартаул иргэнээр таслуулаад зүгээр орхиж болох уу? Ухуна тэргүүтэй зуун элчийн өшлийг өшиж, хяслыг хясаж, Сартаул (Дундад Азийн Туркестан) улстай байлдъя”

“Чингис хаан (баруун зүг) байлдаанд мордоод, Тангуд улсын Бурханд элч явуулж хэлүүлсэн нь: “Баруун гар чинь больё гэж чи хэлсэн бишүү? Сартаул улсад алтан аргамжаа тасдуулаад би хариу авахаар мордов. Баруун гар болж морил!” гэж илгээвэл, Бурханы үг хэлэхийн урьд Аша хамбу өгүүлрүүн: “Хүч хүрэхгүй бол хаан юунд болов?” гээд туслах цэрэг өгсөнгүй омогтой их үг хэлж элчийг буцаажээ. Тэнд Чингис хаан өгүүлрүүн: “Аша хамбуд яаж ингэж хэлэгдэх билээ? Урьдаар тэдэнтэй очиж байлдвал зохилтой бишүү? Гэвч өөр хүнд зорьж байгаа цаг тул энэ удаа больё. Мөнх тэнгэрт ивээгдэж алтан жолоогоо баг татаж ирвэл, тэр цагт магад болтугай!” гэжээ. (Ц.Дамдинсүрэн, Монголын нууц товчоо, УБ.,1947)


а) Эх сурвалжид гарч буй Сартуул иргэн, Тангуд улсын тухай юу мэдэх вэ?

.....

б) Чингис хаан Сартуул иргэн, Тангуд улсад довтолсон шалтгааныг эх сурвалжид хэрхэн тайлбарласан бэ?

.....

Д10 Сурах бичгийн 80-81-р талыг уншин бүдүүвчийг гүйцээгээрэй.



Д11

Эх сурвалжийг задлан шинжлээрэй найзуудаа!



7.2ё

“Шихихутуг наян хоёр настайдаа заргыг шударгаар шүүж ялтнуудад их тусалж энэрч байжээ. Тэр айж цочин хэрэг хүлээх хэрэггүй гэж нэг биш удаа давтан хэлдэг байсан. Айлгүй үнэнээ хэл гэж хэрэгтэн нарт хэлдэг байсан” (Рашид-Ад-дин Судрын чуулган. УБ., 2002)

“Цагадайд Их засаг хуулийн биелэлтэд хяналт тавих, шийтгэл гэсгээлт оногдуулж байх ажлыг хариуцуулна”.

(Жувейни. Дэлхийг байлдан дагуулагчийн түүх. I. УБ., 2006. т.32)

“...бидний дотор дээрээс бэхи Үсүн өвгөн болтугай. Бэхи өргөөд цагаан дээл өмсөж цагаан агт унуулж суурь дээр суулгаж тахиж бас саатаж тийн атугай хэмээн зарлиг болов”. (МНТ. УБ., 2011. т.216)

“Тэд аливаа мөргөл, аливаа шашныг үл хязгаарлана. Хязгаарлах нь битгий хэл тэд бүх шашныг тэтгэн дэмждэг”

(Жувейни. Дэлхийг байлдан дагуулагчийн түүх. I. УБ., 2006. т.12)

а) Цагадай, Шихихутаг нарын хариуцсан ажлыг одоогийн ямар ажилтай адилтгаж болох вэ?

.....

б) Төрийн бэхи ямар үүрэгтэй вэ?

.....

в) Жувейни монголчуудын шашны талаарх бодлогыг хэрхэн дүгнэсэн бэ?

.....

Д12

Дараах тулгуур ойлголтуудыг тайлбартай нь зөв тохируулна уу.

7.1г

Өнчдийн авилга

Их эе

Их хуралдай

Дайн хийх, хааны залгамжлагчийг сонгох зэрэг

Улсын бүх ноёд, жанжид оролцдог

Нийгмийн халамжийн сан

Д13

Монголчууд ямар ахуй, соёлтой байсан бэ?



7.2ж

Эх сурвалжийг задлан шинжлээрэй.

1. “Тэд тэмээ, үхэр, хонь, ямаа, адуугаар үлэмж баян.”
(Плано Карпини. Монголчуудын түүх. УБ., 1988)
2. “Мал сүрэг ихтэй болохоор...хоолонд хэрэглэнэ. ...Махыг нь хатааж борцолно. ...өвөлд бэлтгэн үүцлэн хадгална. Зунд нь гүүний сүү буюу айраг хэрэглэх учир өөр төрлийн хоолонд нэг их санаа тавихгүй”.
(Гильом де Рубрук. Дорно этгээдэд зорчсон минь. УБ., 1988)
3. “Монголчууд хэрвээ мориноосоо салбал юуг ч үл хийж чадна.”
(Рашид-ад-Дин. Судрын чуулган. УБ., 2002)

а) Эх сурвалжид монголчуудын аж ахуй, соёлын талаар юу өгүүлсэн бэ?

.....

б) Нийтлэг болон ялгаатай зүйлс юу байна вэ?

Эх сурвалж	Нийтлэг зүйлс	Ялгаатай зүйлс
П.К		
Г.Р		
Рашид		

в) Монголчуудын эрхлэх аж ахуй, хоол хүнс, түүнийгээ бэлтгэх аргаас юу нь өнөө уламжлан ирсэн бэ?

.....

Д14

Зургийг ажиглан асуултад хариулаарай.

7.2з



XIII-XIV зууны үеийн язгууртны хувцас
(Перс зураачийн бүтээл)



XIII зууны жирийн иргэний дээл
www.nationalcostumedolls.com

а) Монголчууд хувцсаа юугаар голчлон хийж байсан бэ?

.....



б) XIII-XIV зууны Монголчуудын дээл ямар байсан бэ? Өнөөгийн байдалтай харьцуулаарай

Ялгаатай тал

.....

.....

Ижил тал

.....

.....

в) Язгууртны болон энгийн иргэний дээл, зүүсгэлийн ялгааг тайлбарлана уу.

.....

.....

Д15 Дараах эх сурвалжийг задлан шинжлээрэй.

7.2л



Чингисийн чулууны бичгийн агуулга нь: “Чингис хан-и сартагул иргэн дагулижу багужу хамуг монггол улус-ун нойод-и буга сочигай хуригсан-дур Есүнггэ ононодур-ун (онохдоо гэсэн утга) гурбан загуда гучин табун алдас-дур (тоогоор зохицдог байсны баталгаа) ондудла-га (онолоо)” “Чингис хааныг Сартуул иргэдийг дайлан мордож бууж хамаг монгол улсын ардыг Буга сочухайд хурсанд Есүнгэ 335 алдыг онолоо”

а) Эх сурвалж нь он цагийн хувьд хэдий үед холбогдох вэ?

.....

б) Эх сурвалжид юун тухай өгүүлж байна вэ?

.....

в) Яагаад Чингисийн чулууны бичиг гэж нэрлэв?

.....

г) Сартуул, алд гэсэн үгсийн утгыг тайлбарлаарай.

.....

Чингис хаан Монголын их гүрнийг хэрхэн үндэслэсэн тухай судалцгаая найзуудаа!






Д16

Сурах бичгийн 87-90-р талыг уншиж, дараах хүснэгтийг гүйцээнэ үү.

7.2м

Улсууд	Дайлах болсон шалтгаан	Он цаг	Үр дүн
Алтан улс
Хар Хятан
Хорезм
Тангуд

V. Өөрийгөө үнэлээрэй.

Маш сайн ойлгож, хийсэн дасгал, даалгаврууд 	Эргэлзсэн дасгал, даалгаврууд 	Тусламж хэрэгтэй дасгал, даалгаврууд 

Багшийн тэмдэглэл:

.....

Сурагчийн овог нэр: _____

Эхэлсэн_он_сар_өдөр_цаг
 Дууссан_он_сар_өдөр_цаг

VI.ӨРТӨӨ

VI. МОНГОЛЫН ЭЗЭНТ ГҮРЭН

Чингис хааны байгуулсан Их Монгол улс түүний үр хойчсын үед газар нутаг, хүн амаа улам бүр тэлж, дэлхийн түүхэнд урьд, хожид байгаагүй үлэмж том эзэнт гүрнийг байгуулжээ. Эзэнт гүрэн тухайн цагт мэдэгдэж байсан дэлхийн нийт хуурай газрын 80 орчим хувийг эзлэн Ази, Европ тивийг дамнан оршиж байв. Эзэнт гүрний бүрэлдэхүүнд Чингис хааны хөвгүүддээ хуваан захируулсан 4 том улс багтаж байсан агаад тухайн бүс нутгийн ард түмний түүхэнд асар их үүрэг гүйцэтгэсэн байна.

Д1

Өгэдэй хаан Чингисийн тооллын хэдэн онд их суудалд заларсан бэ?

7.2a

Монголчууд билгийн тооллоос гадна Чингис мэндэлсэн 1162 оноос эхэлсэн тооллыг ашиглаж байсныг бид өмнө нь үзсэн. Жишээ нь: Чингис хааны Их Монгол улсын хаан болсон 1206 оныг уг тоололд шилжүүлвэл 45 болох юм.

Сэргээн санаарай найзуудаа!



Д2

Эх сурвалжийг задлан шинжлээрэй.

7.26

- Өгэдэй хаан өгүүлрүүн: "...харьяат улсын сүрэг хонь бүрээс нэжгээд хонь жил тутам авч байна. Зуун хониноос нэжгээд хонь гаргаж улсын доторх үгээгүй ядуучуудын тусламж болгож өгтүгэй. "Зуун хониноос нэжгээд зусаг хонь гаргаж, үгээгүү ядуу хүмүүсийн тусламж болгож өгвөл сайн бий" (МНТ. УБ., 2011. §. 279)
- Өгэдэй хаан өгүүлрүүн: "...усгүй газарт худаг малтуулж гаргуулаад улс иргэнийг ус өвсөнд хүрэлцээтэй болгов" (МНТ. УБ., 2011. §. 281)

а) Эх сурвалжид Өгэдэй хааны хийсэн ямар үйл хэргийн тухай мэдээлсэн байна вэ?

.....

.....

б) Яагаад эх сурвалжид худаг гаргасныг онцолсон бэ?

.....

Д3

7.3а

Өгэдэй хаан Монголын их гүрнийг төвхнүүлсэн тухай доорх тулгуур ойлголтуудыг ашиглан, нэгтгэн дүгнээрэй.

- ◆ Өртөө
- ◆ Худаг
- ◆ Сүм хийд
- ◆ Аян дайн

.....

.....

.....

.....

.....

.....

Хамтдаа судалцгаая найзуудаа!

Тэгвэл Гүюг, Мөнх хаадын үеийн Монголын их гүрэн ямар байсан бэ?



Сурах бичгийн т.96-100-г уншин өгөгдсөн хүснэгтийн дагуу

Д4

Гүюг, Мөнх хааны засаглалын үеийн Монголын их гүрний талаарх мэдээллийг шинжлээрэй.

7.2в

Харьцуулах чиглэл	Их хаан Гүюгийн засаглал	Их хаан Мөнхийн засаглал
а) Төр, цэрэг, засаг захиргаа, хууль
б) Аж ахуй, эдийн засаг, хүн ардын амьдрал
в) Хот, шашин шүтлэг
г) Байлдан дагуулалт

Сурах бичгийн 97-98-р талаас нэмэн дэлгэрүүлээрэй найзуудаа!



Д5

Эх сурвалжийг задлан шинжилнэ үү.

7.2г

Гүюг хааны тамганы дардас



Зураг 4.14.

Уг тамгыг Гүюг хаанаас Ромын Пап лам IV Иннокентийд илгээсэн захидалд даржээ. Тэр захиаг 1920 онд Ватиканы архиваас олсон байна. Тамганы үг нь “Мөнх тэнгэрийн хүчин дор Их Монгол улсын Далай хааны зарлиг ил булха иргэн дор хүрвээс бүширтүгэй аюутугай” юм.

1. Гүюг хааны тамганы дардас хаана хадгалагдаж байна вэ?

.....

2. Ил, булха хэмээх үгсийн утгыг тайлбарлаарай.

.....

3. Уг эх сурвалж бидэнд уламжлагдан ирсэн нь ямар ач холбогдолтой вэ?

.....

Д6

Эх сурвалжийг уншин дараах асуултад хариулаарай.

7.2д

1. “Биньчэн жил (1256 он) нэгэн том суварга босгов. Дээр нь нэгэн сүрлэг сайхан асар барив...Асар нь таван давхар байлаа. Өндөр нь 300 тохой. Хамгийн доод давхар дөрвөн талдаа танхимтай. Танхим бүр долоон тасалгаатай. Тэдгээрийг тойруулаад бурхан багшийн дүр баримлуудыг байрлуулсан. Энэ нь ном сударт заасан ёсонд бүрэн нийцжээ”. (Хархорумын монгол бичээс. 1346)

2. Мөнх хаан “...христос шүтлэгтэн, саррацин, туин...та нарын хэн нь ч өөрийн ёс (шашин)-ыг илүү сайн, бичиг ном (судар ном)-оо илүү үнэн гэдэг. Иймд та нар цөм нэг дор хуран цуглаж, сургаал номоо харьцуулан үзэж, жинхэнэ үнэн зөвийг мэдүүлэхийн тулд хүн бүр дагадаг сургаалаа бичтүгэй гэлээ”. (Г.Рубрук. Дорно этгээдэд зорчсон минь. УБ., 1988. т. 199-204)

а) “Хархорум хотод ямар, ямар шашинтнууд амьдарч байсан бэ? 1256 онд Хархорумд ямар шашны сүм барьж дуусгасан бэ?

.....

.....

.....

Дээр дурдсан хоёр эх сурвалжийг харьцуулан дараах асуултад хариулаарай.

Д7

б) Хоёр эх сурвалжид нийтлэг юу өгүүлсэн бэ?

7.2e

.....

.....

в) Ялгаатай зүйл юу байна вэ?

.....

.....

г) Эдгээр мэдээнээс Мөнх хааны шашны болдогын талаар юу гэж дүгнэж болох вэ?

.....

.....

.....



Монголын Их Юань улсын тухай судалцгаая!



7.2ё

Д8

Зургийг ажиглан сурах бичгийн т.101-0102-т байх мэдээллийн тусламжтайгаар дараах асуултад хариулаарай.

Аригбөх, Хубилай хоёр байлдсан нь



Зураг 4.20. ("Судрын чуулган"-ы чимэг зураг)

а) Зурагт түүхэн ямар үйл явдлыг дүрсэлсэн байна вэ?

.....

.....

б) Яагаад энэ үйл явдлыг зурагт мөнхөлсөн гэж бодож байна вэ?

.....

.....

в) Уг үйл явдал хэрхэн өндөрлөсөн бэ?

.....

Д9 Юань улсын нийгмийн давхраажилтыг оновчтой байрлуулна уу.

7.1a



Монгол

Өнгөт нүдтэн (Уйгар, Араб, Перс)

Өмнөд Хятад (Нанхиад)

Умард Хятад (Зүрчид, Хятан)

Д10

Газарзүйн зургийг ажиглан дараах асуултад хариулаарай.



а) 1.Их Юань улсын газар нутгийн 4 захыг нэрлэнэ үү?

.....

б) Их Юань улсын нийслэл Дайду одоогийн ямар хот вэ?

.....

в) Давааны арын муж гэж ямар газар нутгийг хэлж байсан бэ?

.....

г) Их юань улсын бүрэлдэхүүнд байсан улсуудыг заана уу? Өнөөгийн ямар улс вэ?

.....

Д11 Эх сурвалжийг задлан шинжлээрэй.

7.2з



...Их хааны мөнгө, зоос хийх газар байдаг.

.... Бүх цаасан мөнгөн дээрээ их хааны тамгыг дардаг байжээ. (Марко Поло. Орчлонгийн элдэв сонин. УБ.,1987.т.119)

Хубилай хаан 1260 онд цутгуулсан зоос “Их төрийн гүйлгээний эрдэнэ” гэсэн хятад бичигтай.

а) Мөнгө, зоос хийх эрх мэдэл хэнд байсан бэ?

.....

б) Цаасан мөнгө, зоос хоёрын ялгаа юу вэ?

.....

в) Дээрх зоосыг хятад бичигтэй гаргасан учрыг тайлбарлаарай. Яагаад голдоо дөрвөлжин нүхтэй байна вэ?

.....

Монголын Алтан орд улсын түүхийг судлаарай найзуудаа!



7.2л

Д12 Он цагийг зөв тооцоолоорой.

а) Сурах бичгийн т.108-ыг уншин Алтан орд улсын оршин тогтносон хугацааг тооцоолон он тооллын шугамд байрлуулна уу.



б) Алтан ордны улс байгуулагдсан ба мөхсөн оныг Чингисийн тооллын онд шилжүүлнэ үү.

.....

- ◆ Сурах бичгийн 108-113-р тал
- ◆ Теле хичээл:

- “Монголын Алтан ордны улс”
<https://econtent.edu.mn/lessons/EBS/7rangi/tuuh/1808>

Эргэлзээтэй сэдвээ эндээс хараарай. Хүүхдүүдээ!




Д13

7.16

Алтан ордны улсын түүхийг судлан
Үгийн сүлжээ бөглөгчөө!



1. Алтан орд улсад захирагдсан хүн амын ихэнх нь ямар хүмүүс байсан бэ?
4. Оросын хот улсуудыг хянах, татвар авах үүрэгтэй даргачийг юу гэж нэрлэдэг байсан бэ?
5. Оросын нэгдмэл улс байгуулагдахад аль хот улс голлох үүрэг гүйцэтгэсэн бэ?
7. Алтан орд улс нь аль хааны үеэс бие даасан төр улс болсон бэ?



2. Пап лам Оросын ард түмнийг ямар шашинд оруулахаар шахалт үзүүлж байсан бэ?
3. Ван өөрийн тойрон хүрээлэгсдэдээ газрыг нь эзэмшүүлэх болсоноор шинэ газрын эзэд болох.....бий болов.
4. Алтан орд улс нь Өзбег (1312-1342) хааны үе хүртэл шашинтай байсан бэ?
6. Невийн Александр Бат хааны тусламжтайгаар аль улсын цэргийг бут цохисон бэ?

7.2м

Д14 Эх сурвалжийг задлан шинжлээрэй!

Абдулла хааны гэрэгэ



Зураг 4.25.
ОХУ. Санкт-Петербург
Эрмитаж музей

Алтан орд улсын хаан Абдулла (1367-1368)-ийн мөнгөн гэрэгэ Ижил мөрний сав газраас олджээ. Хэмжээ 28x9 см, жин 359.03 грамм. Монгол бичгээр нэг талд "Мөнх тэнгэрийн хүчин дор Их суу залийн ивээл дор", нөгөө талд нь "Абдулла"-гийн зарлиг хэн үл бишрэх хүн алдах үхэх" гэжээ.

а) Гэрэгэг юунд хэрэглэдэг вэ?

б) Гэрэгэн дээрх бичээсийн утгыг тайлбарлаарай.


.....

.....

Д14

7.1в

Газар зүйн зурагт Алтан орд улсын 4 захыг зөв байрлуулна уу.



а) Эрчис мөрөн

б) Дунай мөрний доод урсгал

в) Дербент (Дагестан)

г) Ижилийн Булгар

7.1г

Монголын Цагадайн улсын түүхээр аялцгаая!



Д15

Сурах бичгийн 113-115-р талыг уншин өгөгдлийг үнэн, худал болохыг тогтоогоорой.

а) Цагадайн улс нь Алгуй хааны үеэс бие даасан.

Үнэн Худал

б) Цагадайн улсад нутгийн иргэд ноёрхох байр суурьтай байв.

Үнэн Худал

в) Хүн амын олонх нь лалын шашин шүтдэг байжээ.

Үнэн Худал

г) Кебек хаан (1319-1326) лалын шашинт хүн байсан.

Үнэн Худал

д) Цагадайн улсын нутаг нь Торгоны замын чухал зангилаа

Үнэн Худал

е) Могулистанд тариачид, гар урчууд илүүтэй амьдарна.

Үнэн Худал

ё) Цагадайн улсын сүүлийн хаан нь Түклүктөмөр юм.

Үнэн Худал

ж) Дотоодын хямралын улмаас Цагадайн улс 1330-аад оны үед 2 хуваагдав.

Үнэн Худал

Д16 **7.2н** Он цагийг зөв тооцоолоорой.


а) Монголын Цагадайн улсын оршин тогтносон хугацааг тооцоолон он тооллын шугамд байрлуулна уу.



б) Цагадайн улс байгуулагдсан ба мөхсөн оныг Чингисийн тооллын онд шилжүүлнэ үү.



Д17 **7.1д** а) Газарзүйн зурагт Цагадайн улсын нийслэл хотуудыг зөв байрлуулаарай.



а) Кашгар

б) Ал малиг

в) Аксу

б) Цагадайн улс нь одоогийн ямар улсуудын нутаг дэвсгэрийг эзлэн оршиж байсан бэ?

.....

Монголын Ил хаант улсын түүхийг судалцгаая найзуудаа!



7.1е

Д18

Сурах бичгийн 116-120-р талыг уншин тулгуур ойлголтуудыг тохирох зайнд нөхөөрэй.

Рашид-ад дин

Хүлэгү

Абу

Марага

Египет

Газан

Багдадын халифт

- а) 1256 онд хаан Ил хаант улсыг байгуулжээ.
- б) Ил хаант улсхаан (1295-1304)-ы үед ихэд хүчирхэгжжээ.
- в) Ил хаант улсын гол дайсан ньбуюу Мамлюкын улс байлаа.
- г) Хүлэгү хаан Исмалайтыг довтлон 1258 ондулсыг мөхөөв.
- д) Сүүлийн хаансайд 1335 онд нас баржээ.
- е) Хүлэгү хаанхотод одон орны төв байгуулав.
- ё) Ил хаант улсын төрийн албан түүх “Судрын чуулган” (Жами-аттаварих)-ыг төрийн сайд1301-1311 онд бичиж дуусгажээ.

Д18

7.2р

Эх сурвалжийг асуултын дагуу задлан шинжилнэ үү.



Өлзийт хаанаас Францын ван Филиппт илгээсэн захидал

“Манай сайн өвөг, сайн эцэг, сайн ахтай (та нар) найрамдалтай явсан журмаа үл эвдэх буй за... Эдүгээ бидэнд ба та нарт үл зохилдон эвлэх (этгээдийг) тэнгэрийн хүчээр цөм хамтран эсэргүүцэж байхыг тэнгэр мэдтүгэй.”

а) Захидалд юуны тухай өгүүлж байна вэ?

.....

б) Захидлыг ямар бичгээр бичиж, хэрхэн баталгаажуулсан байна вэ?


.....

в) Энэхүү түүхэн баримт өнөө үед ямар ач холбогдолтой вэ?

.....

Д19 а) Газарзүйн зурагт Ил хаант улсын нийслэл хотыг зөв байрлуулаарай.

7.1ö



а) Марага




б) Султания

в) Тебриз

б) Монголын Ил хаант улс нь одоогийн ямар улсуудын нутаг дэвсгэрийг эзлэн оршиж байсан бэ?

.....

VI. Өөрийгөө үнэлээрэй.

<p>Маш сайн ойлгож, хийсэн дасгал, даалгаврууд</p> 	<p>Эргэлзсэн дасгал, даалгаврууд</p> 	<p>Тусламж хэрэгтэй дасгал, даалгаврууд</p> 
<p> </p>	<p> </p>	<p> </p>

Багшийн тэмдэглэл

.....

.....

.....

Сурагчийн овог нэр: _____

Эхэлсэн_он_сар_өдөр_цаг
 Дууссан_он_сар_өдөр_цаг

v.ӨРТӨӨ

VII. ЧИНГИСИЙН ЭРИН ҮЕИЙН ДЭЛХИЙ ДАХИН (XII-XV) ЗУУН

XIII-XIV зуунд Англи, Франц, Испани улсууд улс төрийн бутралаа даван туулж нэгдсэн улсаа байгуулав. Пап лам тэргүүтэй католик сүм, хийдүүд хүчирхэгжин хаант засгийн зэрэгцээ шатлан захирах тогтолцоо бүхий хүчирхэг байгууллага болж, Европын улсуудын сүм хийдийг захирч байжээ. Европ даяарх сүм хийдийн орлого бүхэлдээ Ватикан руу урссанаар католик сүм, хийдийн эд баялаг хэмжээлшгүй болж, Пап ламын эрх мэдэл хаадынхаас хол давжээ. Гар урчууд, худалдаачдын суурингаас өндийсөн Европын хотууд хүрээгээ улам бүр тэлж, хүн амын нягтрал ихтэй аварга том хотууд сүндэрлэх болов.

Сурах бичгийнхээ 122-125-р талыг уншин Феодал ба тариачдын амьдралын тухай судлаарай.



Д1

7.1a

Өгөгдлийг уншин өмнөх үсгийг хүснэгтэд ялган бичээрэй.

а) Талбай, ой, нуга, мөн гол, нуур хүртэл тэдний өмч.

б) Тэд шилтгээнд амьдарч байв.

в) Тэд аж ахуйгаа хариуцуулах даамал ажиллуулж байв.

г) Тэднийг цэрэг дайны үйл хэрэгт бага наснаас нь бэлтгэдэг.

д) Тулааны ялагч өрсөлдөгчийнхөө морь, бамбайгаар шагнуулна.

е) Тэд тосгонд амьдардаг.

ё) Тэд дайн тулаанд ялах, хаан өргөмжлөх, язгууртны хуримын үеэр халз тулалдана.

ж) Тэд алба, гувчуураа хожимдуулвал торгууль, шийтгэл хүлээнэ.

з) Тэд ноогдол газраа үе залгамжлан эзэмшиж, эзэндээ алба гувчуур барина.

л) Тэд эзний зөвшөөрөлгүйгээр тосгоноо орхиж, ноогдол газраа худалдах, шилжүүлэх эрхгүй.


м) Тэд өөрийн эздийн шүүхээр асуудлаа шийдвэрлүүлдэг.

Феодал	Рыцарь	Тариачин

Д2

Зургийг ажиглан өгөгдсөн асуултад хариулна уу.

7.2a



1. Донжон (гол цамхаг).
2. Бэхлэлт хана.
3. Хамгаалалтын цамхаг.
4. Дотор хашаа
5. Хаалга, дээд талынх нь цамхаг
6. Гүүр.
7. Шуудуу.
8. Далан.

а) Шилтгээнийг юугаар барьж байсан бэ?

.....

б) Феодалууд шилтгээнээ хаана барьдаг байсан бэ? Яагаад?

.....

в) Шилтгээний гадуур шуудуу гаргасан байгаагийн учрыг таамаглаарай.

.....

7.26

Сурах бичгийнхээ 126-128-р талыг уншин дундад зууны хотуудын талаар мэдэцгээе!




Д3

Он тооллын шугамд түүхэн үйл явдлыг он цагийн зөв дарааллаар байрлуулна уу.

VIII-IX зуунд Европт 10000-аас дээш хүн амтай хэдэн арван хот байгуулагдав.

XI-XV зуунд Европ даяар хэдэн мянган хот байгуулагдав. Тэдний зарим нь 200 мянга давсан хүн амтай байв.



XVI зуунд "Хар тахал" дэгдэж үйл олон хүмүүс үрэгдэв.

X зуунд Европт гар үйлдвэрлэл хөгжих нөхцөл бүрджээ.

XII-XIII зуунд хотынхон эрх чөлөөгөө худалдан авч коммун (өөрийн удирдагатай хот) болов

Д4 Дараах эх сурвалжийг асуултын дагуу задлан шинжлээрэй.

7.2в

1. Ландрик Толсты (феодал) би Ланграгийн нэгэн худалдаачныг манай нутгаар өнгөрөхөд нь ... эд барааг нь булаан авав ... миний эзэмшлээр чөлөөтэй өнгөрч байхын тулд ... алба төлж байхаар тохиролцов.
2. Худалдаачдыг чөлөөтэй худалдаа хийлгэж байхын тулд хот бүхэн өөрийн хүчээр далайн дээрэмчдээс ... хамгаалж байна.
3. Хэрэв манай хот, хотын орчимд ирсэн ямар нэгэн худалдаачин манай гильдэд эс орвол түүнийг хөөх буюу эд хөрөнгийг нь хураан авна.

а) Худалдаачдын эд барааг хэн, юуны учир булаан авсан бэ?

.....

б) Худалдаачдыг хэн хамгаалж байв?

.....

в) Гильд гэж юу вэ? Ямар үүрэгтэй вэ?

.....

Д5 Дундад зууны Европт хотууд үүсэх шалтгаан ба үр дүнг тайлбарлаарай.

7.2г

Шалтгаан

Үр дүн

.....
.....
.....
.....

Хүүхдүүд ээ! сурах бичгийн 129-134-р талыг уншиж Загалмайтны сүмийн хүчирхэгжилт ба аян дайнуудын тухай судлаарай.



Д6 Эх сурвалжийг асуултын дагуу задлан шинжилнэ үү.

7.2д

- Зөвхөн тэр л хамба лам нарыг томилох, огцруулах эрхтэй.
- Гагцхүү пап л хаанд өргөмжилнө.
 - Бүх хаад гагцхүү папын хөлийг үнсэх ёстой.
 - Тэр эзэн хааныг огцруулж болно. (Пап лам VII Григорийн (1073-1085) зарлигаас)

а) Эх сурвалжид хамба лам гэж хэнийг хэлсэн бол?

.....

б) Пап болон Европын хаадуудын харилцааг хэрхэн дүгнэж болох вэ?

.....

Д7 **7.16** Хүснэгтээс тулгуур ойлголтыг олон тохирох зайнд зөв нөхөөрэй.

э	п	а	п	а	н	и	л	г	у	⇒	Католик шашны тэргүүнийг Пап гэнэ.
р	б	д	а	х	а	р	м	а	о	⇒	Загалмайтнуудын дагаж мөрдвөл зохих зан суртахууныг заасан байдаг.
ө	и	н	к	в	и	з	и	ц	и	⇒	Сүм хийдийн жинхэнэ нүүр царайг илчлэгч хүмүүсийг тэрслүү үзэлтэн хэмээн нэрлэж, католик сүмийн шүүхээр.....хатуу шүүн, гэсгээж байжээ.
и	б	о	г	у	н	о	м	ц	о	⇒	Сүсэгтнүүд гэм нүглийн жагсаалтаа гарган бурхны өршөөлийг хүртэх зорилгоор сүм хийдэд..... төлдөг байв.
а	л	и	б	ө	д	б	о	з	р	⇒хатуу дэг бүхий сүмийн байгууллага.
о	и	л	м	и	у	т	н	ш	д		
ф	ц	б	э	н	л	г	м	р	е		
й	ы	ч	х	ү	ь	р	э	г	н		
ө	р	к	ь	о	г	т	ь	г	и	⇒	
с	м	а	р	о	е	ё	ж	р	ь		
я	ч	ө	с	м	н	и	т	о	л		
й	ы	а	с	м	ц	р	л	д	в		
ё	х	м	н	ь	и	ө	л	з	т		

Д8 Сурах бичгийн т.132-134-ыг уншин Загалмайтны аян дайны шалтгаан, үр дүнг холбон тайлбарлана уу.

7.3а

Шалтгаан	Үр дүн
.....
.....
.....
.....
Дүгнэлт	
.....	
.....	

Д9

Сурах бичгийн 136-141-р талыг уншиж, XIII-XV зуунд Европын улсууд тархай, бутархай байдлаа даван туулж, нэгдсэн төр улс байгуулагдсан үйл явдлыг дараах асуултын дагуу харьцуулаарай.

7.2e

Асуулт	Англи	Франц	Испани
Хаад эрх мэдлээ хэрхэн тэлэв? Ямар бодлого явуулав?			
Улс орноо ямар арга замаар нэгтгэв?			
Нэгдсэн төр улс байгуулагдсаны ач холбогдол юу байв?			

Д10

Сурах бичгийн т.142-145-ыг уншиж, “Баруун Европын соёл” сэдвийн хүрээнд дараах асуултад хариулна уу.

7.1в

Би хэн бэ?



Парис, Оксфордын их сургуулиудад багшилж байв. Тэрээр шавь нартаа мэдлэгийг туршлагаар батлах ёстой хэмээн сургаж байсан

.....

Би юу вэ?



Би хүний хэлбэртэй. Намайг барилга байгууламж дээр товгор сийлбэрээр чимэглэжээ.

.....

Би хаана байна вэ?



Шовх ороотой цамхаг, гоёмсог багануудын дунд зогсож байна.

.....

Д11

Зургийг ажиглан уран барилгын хийцийн ялгаатай шинжүүдийг тэмдэглээрэй.

7.1г



Роман хийц



Гот хийц

.....

Д12 Сурах бичгийн 146-147-р талаас “Византийн эзэнт улсын мөхөл” сэдвийг уншиж, түүхэн үйл явдлыг болсон цаг хугацаатай нь зөв холбоно уу.

7.1д

.....Флоренцийн сүмийн чуулган дээр загалмайтны шашны сүм хийдүүд нэгдэх хэлэлцээр хийжээ



.....туркууд Косовогийн талын тулалдаанд сербүүдийг ялж, улмаар Болгарын хаант улсыг эзлэв.



.....загалмайтнуудыг Константинополиос хөөв.



.....Османы султан Баязид Дундад Азиас ирсэн Доголон Төмөрт Анкарагийн дэргэд ялагдал хүлээнээр хотын сүйрэл хагас зуун жилээр хойшилжээ.



.....Турк-Османчууд Византын эзэнт улсыг мөхөөв.



Д13 Эх сурвалжийг задлан шинжлээрэй.

7.2ё

«...Дайны ялалт (5 сарын 29-нд ерөнхий дайралтын үеэр) туркуудын талд шилжив... Хананд шат тавин авирах дайснуудтай тулгарсан ромей, латинчууд нэг бол тэдэнд цавчуулан унаж, үгүй бол нүдээ анин хананаас унаж, бие нь бяцарч байгаа аймшигт дүр зургийг харж болох байв. Туркууд одоо ямар ч саадгүйгээр хананд шатаа босгож, нисэж буй бүргэд мэт хана руу авирч эхлэв ...»

Нэг ромейн эсрэг хорин эрэлхэг турк тулалдаж... байснаас гадна ромей нар тийм ч эрэлхэг цэргүүд биш байв...

Тэд (туркууд) хотод орж, хаалганаас ордон хүрэх зуур замдаа тааралдсан, зугатаж байгаа хэнийг ч болов нэг бүрчлэн хядав. Ийнхүү тэд 2000 цэрэг эрсийг хяджээ... Тэгээд бүх эр, эм хүн, лам, гэлэнмаа нар орон гэрээ орхин хүүхдээ тэврэн Их сүм рүү гүйлдэв. Гэвч бүгд Их сүмд зугатан орогнож чадах уу?... Ийнхүү үлэмж сүм тэр дороо л хүмүүсээр дүүрэв.

Туркууд тал тал тийш гүйлдэн алж хядан, заримыг нь олзлон өглөө болоод нэг цаг ч өнгөрөөгүй байхад сүмд тулж ирцгээлээ, тэд хаалгыг цоожилсныг хараад сүхээр эвдэв. Сэлмээр зэвсэглэсэн цэргүүд дотогшоо орж, олон хүнтэй тулгарч, хүн бүр өөрийн олзны хүнийг олзлон авав...Эмэгтэйчүүдийг алчуураар нь холбожээ. Сүмээс олзны хүмүүс тасралтгүй цуварч, уйлж, гинших нь сонсогдоно. Сүмийн тухай би юу өгүүлж чадах билээ? Хэлсэн ч гаслан хашгирах биз ээ. Эсвэл хоолой минь арган хатаж, амьсгал давчдан амнаас минь үг ч гарахгүй биз ээ. Нэг хормын дотор нохос гэгээнтний хөргийг цавчин чимэглэл, зүүлт, бугуйвч, ёслолын хувцсыг нь дээрэмдэв. Гайхамшигт цөгцийг нэг бол эвдлэн үгүй бол өвөрлөн ариун идээний үнэт сав суулга, алт, мөнгөн эдлэл зэрэг авч болох бүхнийг тэр даруй дээрэмдэн сүмийг хоослов. (Михаил Дука (XV зуун) –Византийн түүхч. Туркууд Константинополийг эзэлсэн нь.)

а) Ромейчууд гэж хэн бэ?

.....

б) Эх сурвалжид юун тухай өгүүлж байна вэ?

.....




.....

в) Булаан эзлэгчдийн авир үйлдлийг зохиогч хэрхэн тодорхойлсон бэ?

.....

.....

VII. Өөрийгөө үнэлээрэй.

<p>Маш сайн ойлгож, хийсэн дасгал, даалгаврууд</p> 	<p>Эргэлзсэн дасгал, даалгаврууд</p> 	<p>Тусламж хэрэгтэй дасгал, даалгаврууд</p> 

VII. Багшийн тэмдэглэл

.....

.....

.....

.....

.....

.....

Суурь боловсролын Түүхийн сурлагын хоцрогдлыг нөхөх, арилгах “Бие даан ажиллах дэвтэр”-ийн сурагчдад өгөх зөвлөмж

Бие даан ажиллах дэвтрийн дасгал, даалгаврын түвшин, тэмдэглэгээ:

Тэмдэглэгээ

Тайлбар

7.1a

7 - Анги

7.1a

1 – I түвшний даалгавар (улаан өнгө)

7.1a

2 – II түвшний даалгавар (шар өнгө)

3 – III түвшний даалгавар (ногоон өнгө)

a – Даалгаврын дугаар (Жишээ: a-1, б-2, в-3 гэх мэт)

Суралцахуйн зураглалтай ажиллах алхам:

- I алхам: Багшийн зөвлөсөн дасгал даалгавруудаас эхлэн ажиллаарай.
- II алхам: Хийж чаддаг болсон дасгал, даалгавруудаа тохирох түвшний өнгөөр будна уу.
- III алхам: Тухайн бүлгийн дасгал, даалгавруудыг гүйцэтгэж эхэлсэн болон дуусгасан хугацаагаа тэмдэглэнэ.
- IV алхам: Дасгал, даалгаврыг гүйцэтгэсний дараа өөрийгөө үнэлээрэй.
- V алхам: Багшаараа үнэлүүлэн өгсөн зөвлөмжийн дагуу сайжруулна уу.

Энэ хүртэл хамтдаа аялсан найзууддаа баярлалаа. Та нартаа амжилт хүсье!



Бүлэг	V. Их Монгол улс	VI. Монголын эзэнт гүрэн	VII. Чингисийн эрин үеийн дэлхий дахин (XII-XV) зуун
Түвшин	—	—	—
Дасгал	7.1a 7.1б 7.1г 7.1д 7.1е 7.1ж 7.1з 7.1и 7.1к 7.1л 7.1м 7.1н 7.1о 7.1п 7.1р 7.1с 7.1т 7.1у 7.1ф 7.1х 7.1ц 7.1ч 7.1ш 7.1щ 7.1ъ 7.1ь 7.1я 7.1а 7.1б 7.1в 7.1г 7.1д 7.1е 7.1ж 7.1з 7.1и 7.1к 7.1л 7.1м 7.1н 7.1о 7.1п 7.1р 7.1с 7.1т 7.1у 7.1ф 7.1х 7.1ц 7.1ч 7.1ш 7.1щ 7.1ъ 7.1ь 7.1я	7.2a 7.2б 7.2в 7.2г 7.2д 7.2е 7.2ж 7.2з 7.2и 7.2к 7.2л 7.2м 7.2н 7.2о 7.2п 7.2р 7.2с 7.2т 7.2у 7.2ф 7.2х 7.2ц 7.2ч 7.2ш 7.2щ 7.2ъ 7.2ь 7.2я	7.3a 7.3б 7.3в 7.3г 7.3д 7.3е 7.3ж 7.3з 7.3и 7.3к 7.3л 7.3м 7.3н 7.3о 7.3п 7.3р 7.3с 7.3т 7.3у 7.3ф 7.3х 7.3ц 7.3ч 7.3ш 7.3щ 7.3ъ 7.3ь 7.3я
Эхэлсэн			
Дууссан			
Өөрийн үнэлгээ			
Батшлын үнэлгээ			